



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА
ЭРХЛЭГЧДИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар

Улаанбаатар хот
2024 он



АГУУЛГА

1

САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2

АРИЛЖААНЫ МЭДЭЭ

3

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ**

4

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

5

ДУГНЭЛТ



Товчилсон үгийн тайлал

1. Хороо-Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
3. АНУ - Америкийн Нэгдсэн Улс
4. ХБНГУ - Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
5. БНИУ - Бүгд Найрамдах Ирланд Улс
6. ХЭ - Хувьцаа эзэмшигч
7. ХНХ - Хувь нийлүүлсэн хөрөнгө
8. ГХО - Гадаадын хөрөнгө оруулалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил

Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 3. Орлогын тайлангийн үзүүлэлт

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Дүрслэл 2. Салбар нээх хүсэлт болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн шийдвэрлэлт

Дүрслэл 3. Арилжаа эрхлэгчид байршлаар

Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Дүрслэл 6. ГХО-ын дэлгэрэнгүй

Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчид

Дүрслэл 8. Үнэт металлын борлуулалтын хэмжээ

Дүрслэл 9. Алтны борлуулалтын хэмжээ

Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын хэмжээ

Дүрслэл 11. Үнэт эдлэлийн борлуулалтын мэдээ

Дүрслэл 12. Монголбанкны худалдан авсан үнэт металлын мэдээ

Дүрслэл 13. Монгол Улсын худалдан авахаар төлөвлөсөн алт болон Монголбанкны худалдан авсан алт (2020-2023 он)



Хураангуй

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид:

Хорооноос 2024 оны эхний хагас жилд 25 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор 53 хуулийн этгээд, 453 иргэн энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр Хороонд бүртгэгдсэн.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс салбар нээн ажиллуулах тухай 3 хүсэлт, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх тухай 1 хүсэлт тус тус ирүүлснийг хянаж, шийдвэрлэлээ.

Арилжааны мэдээ, санхүүгийн үзүүлэлт:

Тайлант улиралд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 53 хуулийн этгээд нь 85 хувьцаа эзэмшигчийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 53.4 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 46.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Нэр бүхий 53 хуулийн этгээд нь тайлант хугацаанд 42,420,078.5 мянган төгрөгийн нийт орлоготой, 34,713,462.3 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлснээр 7,706,616.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өсжээ.

Энэ оны эхний хагас жилд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 928.2 кг үнэт металлыг 148,201,987.2 мянган төгрөгөөр худалдан авч, 651.4 кг үнэт металлыг 144,590,817.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.9 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.1 дахин өссөн байна.

Мөн ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 11,623,657.1 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 20,103,372.4 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан үнэт эдлэлийн дүн 1.4 дахин, худалдан борлуулсан үнэт эдлэлийн 1.7 дахин тус тус өссөн үзүүлэлт юм.


Хурал уулзалт:

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр “Mongolian jewellery&metal forum” арга хэмжээг "Асуудал, Шийдэл, Боломж" ерөнхий сэдвийн хүрээнд "Үнэт металлын салбар дахь олборлолт ба боловсруулалт", "Үнэт металлын салбар дахь үйлдвэрлэл, үйлчилгээ", "Үнэт металлын салбар дахь арилжаа, хөгжих боломж" сэдэвт дэд хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа.

Хорооны төлөөлөл 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд Франц улсын нийслэл Парис хотноо зохион байгуулагдсан "Хариуцлагатай ашигт малтмалын нийлүүлэлт сүлжээ" сэдэвт форумд оролцон Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD), Дэлхийн алтны зөвлөл (WGC), Аргор Хереаус зэрэг олон талуудтай уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, мэдээлэл солилцох, мэдлэг түгээх, оролцогч талуудыг чадавхжуулах, хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцов.


Хорооноос Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо болон “Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр төсөл” (planetGOLD Mongolia)-тэй хамтран ҮМҮЧЭТХЭАЭ иргэдэд зориулсан сургалтыг Говь-Алтай (31 оролцогч), Ховд (35 оролцогч), Сэлэнгэ аймагт (28 оролцогч) 2024.05.06-наас 2024.05.24-ний өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 94 оролцогч хамрагдлаа.

Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 53 хуулийн этгээд, 453 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 4-өөр нэмэгдсэн бол иргэдийн тоо 8-аар буурсан үзүүлэлт юм.



Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчид салбар нээн ажиллуулах, эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх тухай 4 хүсэлт Хороонд ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн. Эдгээр хүсэлтийг төрлөөр нь ангилан дүрслэл 2-т үзүүлэв.



Дүрслэл 2. Салбар нээх хүсэлт болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн шийдвэрлэлт


Тайлант хугацаанд буюу 2024 оны эхний хагас жилд нэр бүхий 25 иргэнээс дээрх төрлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлт ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, шийдвэрлэсэн.

Тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгч иргэдийн 74.0 хувь буюу 335 нь Улаанбаатар хотод, 26.0 хувь буюу 118 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдүүдийг байршлаар ангилбал:

Дүүрэг	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд
Сүхбаатар	4	7	4	14
Хан-Уул	2	8	1	13
Баянзүрх	4	7	8	3
Чингэлтэй	53	164	29	16
Баянгол	9	17	3	4
Сонгинохайрхан	5	9	1	2
Орон нутаг	34	8	76	1

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 118 иргэдийн 78.8 хувь буюу 93 нь Баянхонгор, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 21.2 хувь буюу 25 нь Увс, Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай, Дорноговь, Дорнод, Хэнтий аймгуудад үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн тусгай зөвшөөрөлтэй 53 хуулийн этгээдийн 1 нь орон нутагт буюу Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлж байна. Арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхэлж буй байршлын дэлгэрэнгүйг дүрслэл 3-т үзүүлэв.





Дүрслэл 3. Арилжаа эрхлэгчид байршлаар

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 53 хуулийн этгээд нь 85 хувьцаа эзэмшигчийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 9.0 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

↑5.3%




Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ


ҮМҮЧЭТХЭАЭ 53 хуулийн этгээдийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 53.4 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 46.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийг дүрслэл 5-д үзүүлэв.

Нийт гадаадын хөрөнгө оруулалтын 79.8 хувь буюу 3,739,923.0 мянган төгрөгийг БНСУ-ын хөрөнгө оруулалт эзэлж байгаа бол 20.2 буюу 949,000.0 мянган төгрөгийг АНУ, Япон, ХБНГУ, БНИУ-ын хөрөнгө оруулалт эзэлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүйг дүрслэл 6-д үзүүлэв.


Гадаадын хөрөнгө оруулалт



Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц



Дүрслэл 6. ГХО-ын дэлгэрэнгүй



Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчид

Тусгай зөвшөөрөлтэй 53 хуулийн этгээдийн 34 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 13 нь 2 хувьцаа эзэмшигчтэй, 6 нь 3 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн тоогоор нь ангилан дүрслэл 7-д үзүүлэв.

2024 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэл

Үнэт металлын борлуулалтын тойм

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 928.2 кг үнэт металлыг 148,201,987.2 мянган төгрөгөөр худалдан авч, 651.4 кг үнэт металлыг 144,590,819.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.9 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.1 дахин тус тус өссөн үзүүлэлтэй байна. Үнэт металлын борлуулалтыг дүрслэл 8-д үзүүлэв.



Дүрслэл 8. Үнэт металлын борлуулалтын хэмжээ

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2024 оны эхний хагас жилд 617.1 кг алтыг 146,988,661.6 мянган төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 1.4 дахин, үнийн дүн 2.3 дахин өсжээ. Харин 584.6 кг алтыг 143,704,981.1 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 1.1 дахин, үнийн дүн 1.9 дахин өссөн үзүүлэлт юм. Алтны борлуулалтын хэмжээг дүрслэл 9-д үзүүлэв.



Дүрслэл 9. Алтны борлуулалтын хэмжээ

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 311.1 кг мөнгийг 1,213,325.6 мянган төгрөгөөр худалдан авч, 66.8 кг мөнгийг 885,838.7 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 7.7 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1.8 дахин өссөн үзүүлэлт юм.



Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын хэмжээ

Үнэт эдлэлийн борлуулалтын тойм



Дүрслэл 11. Үнэт эдлэлийн борлуулалтын дүн (мянган төгрөг)

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ иргэн, хуулийн этгээдүүд 11,623,657.1 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 20,103,372.4 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан үнэт эдлэлийн дүн 1.4 дахин, худалдан борлуулсан үнэт эдлэлийн 1.7 дахин тус тус өссөн үзүүлэлт юм.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.II	Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ	2024.II	Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,775,658.8	24.7%	17,557,572.0	23.5%
Дансны авлага	2,447,915.6	4.4%	3,233,191.4	4.3%
Татвар, НДШ – ийн авлага	463,524.6	0.8%	403,413.0	0.5%
Бусад авлага	1,069,148.7	1.9%	1,016,009.3	1.4%
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-	-	-
Бараа материал	22,277,254.3	40.0%	31,541,395.9	42.1%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,303,624.6	5.9%	6,703,993.8	9.0%
Бусад эргэлтийн хөрөнгө	451,245.6	0.8%	451,245.6	0.6%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,756,445.6	3.2%	1,756,445.3	2.3%
Эргэлтийн хөрөнгийн дүн	45,544,817.4	81.7%	62,663,266.2	83.7%
Үндсэн хөрөнгө	9,458,602.7	17%	11,230,070.5	15.0%
Биет бус хөрөнгө	269,553.0	0.5%	533,584.0	0.7%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	407,474.1	0.7%	407,374.1	0.5%
Хойшлогдсон татварын хөрөнгө	34,450.1	0.1%	34,450.1	0.1%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,183,980.0	18.3%	12,205,478.7	16.3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	55,728,797.3	100%	74,868,745.0	100.0%
Дансны өглөг	14,029,006.0	25.2%	17,721,476.5	23.7%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	1,535,359.9	2.8%	1,894,896.4	2.5%
Банкны богино хугацаат зээл	2,377,177.3	4.3%	2,537,386.1	3.4%
Хүүний өглөг	784,015.0	1.4%	889,225.0	1.2%
Ногдол ашгийн өглөг	675,000.0	1.2%	202,500.0	0.3%
Урьдчилж орсон орлого	1,464,566.2	2.6%	5,506,543.1	7.4%
Нөөц /өр төлбөр/	15,067.7	0%	16,307.7	0.0%
Бусад богино хугацаат өр төлбөр	5,487,045.6	9.8%	7,027,472.9	9.4%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	26,367,237.6	47.3%	35,795,807.8	47.8%
Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-
Урт хугацаат зээл	4,780,152.3	8.6%	6,821,229.6	9.1%
Хойшлогдсон татварын өр	3,718.1	0%	33,761.1	0.0%
Бусад урт хугацаат өр төлбөр	121,024.3	0.2%	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,904,894.8	8.8%	6,854,990.7	9.1%
Өр төлбөрийн нийт дүн	31,272,132.4	56.1%	42,650,798.5	57.0%
Өмч	9,554,429.1	17.1%	10,063,429.1	13.4%
- хувийн	9,554,429.1	17.1%	10,063,429.1	13.4%
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-	-
Халаасны хувьцаа	2,278,232.1	4.1%	2,278,232.1	3.0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	215,792.6	0.4%	288,263.8	0.4%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,164,441.9	2.1%	1,105,664.6	1.5%
Хуримтлагдсан ашиг	11,243,769.3	20.2%	18,482,357.0	24.7%
Эздийн өмчийн дүн	24,456,665.0	43.9%	32,217,946.5	43.0%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	55,728,797.4	100%	74,868,745.0	100.0%

2023.II

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2023 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 49 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 78 хувьцаа эзэмшигчдийн 9,554,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 55,728,797.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Эргэлтийн
хөрөнгө

81.7%

Эргэлтийн
бус хөрөнгө

18.3%

Эздийн өмч

43.9%

Өр төлбөрийн
хэмжээ

56.1%

2024.II он

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2024 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 53 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 85 хувьцаа эзэмшигчдийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 74,868,745.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Эргэлтийн
хөрөнгө

83.7%

Эргэлтийн
бус хөрөнгө

16.3%

Эздийн өмч

43.0%

Өр төлбөрийн
хэмжээ

57.0%

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нийт хөрөнгө, хуримтлагдсан ашиг, өр төлбөрийн нийт дүнд дараах байдлаар өөрчлөлт орсон байна.

Хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээ



Нийт хөрөнгийн
дүн



Хуримтлагдсан
ашигийн хэмжээ





Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2023.II

2024.II

Нийт орлого

28,773,033.5 мянган төгрөг

Борлуулалтын орлого

28,298,798.6 мянган төгрөг

Нийт зардал

23,433,903.1 мянган төгрөг

Цэвэр ашиг **5,339,130.4**
мянган төгрөг

Нийт орлого

42,420,078.5 мянган төгрөг

Борлуулалтын орлого

42,011,050.8 мянган төгрөг

Нийт зардал

34,713,462.3 мянган төгрөг

Цэвэр ашиг **7,706,616.2**
мянган төгрөг

- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 53 хуулийн этгээд нь 42,420,078.5 мянган төгрөгийн нийт орлоготой, 34,713,462.3 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 7,706,616.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өссөн үзүүлэлт юм.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 99 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2023.II		2024.II		Өөрчлөлт (+/-)	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
Борлуулалтын орлого (цэвэр)	28,298,798.6	98.4%	42,011,050.8	99.0%	13,712,252.2	48.5%
Түрээсийн орлого	311,849.1	1.1%	313,849.1	0.7%	2,000.0	0.6%
Хүүний орлого	17,942.9	0.1%	46,074.1	0.1%	28,131.2	156.8%
Бусад орлого	142,286.2	0.5%	47,629.2	0.1%	-94,657.0	-66.5%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	2,156.7	0.0%	1,475.3	0.0%	-681.4	-31.6%
Нийт орлого	28,773,033.5	100.0%	42,420,078.5	100.0%	13,647,045.0	47.4%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	15,579,027.3	66.5%	21,843,155.7	62.9%	6,264,128.4	40.2%
Борлуулалт, маркетингийн зардал	3,385,884.9	14.4%	5,095,974.7	14.7%	1,710,089.8	50.5%
Ерөнхий ба удирдлагын зардал	3,243,861.4	13.8%	5,091,032.9	14.7%	1,847,171.5	56.9%
Санхүүгийн зардал	390,633.4	1.7%	985,851.8	2.8%	595,218.4	152.4%
Бусад зардал	149,241.2	0.6%	359,167.7	1.0%	209,926.4	140.7%
Татварын зардал	559,508.3	2.4%	903,843.3	2.6%	344,335.0	61.5%
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	64,505.6	0.3%	385,436.2	1.1%	320,931.0	497.5%
Бусад алдагдал	61,420.9	0.3%	48,999.6	0.1%	-12,421.2	-20.2%
Нийт зардал	23,433,903.1	100.0%	34,713,462.2	100.0%	11,279,559.2	48.1%
Тайлант үеийн цэвэр ашиг	5,339,130.4		7,706,616.2		2,367,485.8	44.3%



Монголбанк 2024 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 236 харилцагчаас 7.8 тонн үнэт металлыг 1.2 их наяд төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс худалдаж авсан үнэт металлын хэмжээ 0.5 тонноор өссөн байна.

Дээрх 236 харилцагчийн 61.4 хувь буюу 145 нь аж ахуйн нэгж, 38.6 хувь буюу 91 нь иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс аж ахуйн нэгжийн тоо 22-оор, иргэдийн тоо 73-аар тус тус буурсан үзүүлэлт юм.



Дүрслэл 12. Үнэт металлын хэмжээ



Өнгөрсөн оны эхний хагас жилд 1 грамм алтны дундаж үнэ 216,349.34 төгрөг байсан бол энэ оны эхний хагас жилд 1 грамм алтны дундаж үнэ 239,483.73 төгрөгт хүрч 10.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр “Mongolian jewellery&metal forum” арга хэмжээг "Асуудал, Шийдэл, Боломж" ерөнхий сэдвийн хүрээнд "Үнэт металлын салбар дахь олборлолт ба боловсруулалт", "Үнэт металлын салбар дахь үйлдвэрлэл, үйлчилгээ", "Үнэт металлын салбар дахь арилжаа, хөгжих боломж" сэдэвт дэд хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж, 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрөөс 04 дүгээр сарын 14-ний өдрүүдэд “Mongolian jewellery&metal forum” экспод оролцсон.




Хорооны төлөөлөл 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрүүдэд Франц улсын нийслэл Парис хотноо зохион байгуулагдсан "Хариуцлагатай ашигт малтмалын нийлүүлэлт сүлжээ" сэдэвт форумд оролцон Эдийн засаг, хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD), Дэлхийн алтны зөвлөл (WGC), Аргор Хереаус зэрэг олон талуудтай уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, мэдээлэл солилцох, мэдлэг түгээх, оролцогч талуудыг чадавхжуулах, хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцсон.



Хурал, уулзалт

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр нэр бүхий 4 төрийн байгууллага, (Монголбанк, Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Ашигт малтмал, газрын тосны газар) 3 мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр хамтарсан уулзалтыг зохион байгуулав.

Монголбанкны Эрдэнэсийн сан, Хороо болон Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо нь 2024.05.28-ны өдөр хамтарсан уулзалт хийж, санал солилцон, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.



Хорооноос “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо” ГҮТББ болон “Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр төсөл” (planetGOLD Mongolia)-тэй хамтран ҮМҮЧЭТХЭАЭ иргэдэд зориулсан сургалтыг Говь-Алтай (31 оролцогч), Ховд (35 оролцогч), Сэлэнгэ аймагт (28 оролцогч) 2024.05.06-наас 2024.05.24-ний өдрүүдэд зохион байгуулсан ба нийт 94 оролцогч хамрагдсан.

- Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газар, Хорооны орон нутгийн төлөөлөгчид болон салбарын оролцогчдод зориулан Хорооноос хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, бүртгэл зөвшөөрөл, зайны болон газар дээрх хяналт шалгалт, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар мэдлэг, мэдээлэл олгох цахим сургалтыг 2024.02.24-ний өдөр зохион байгуулж, нийт 104 оролцогч хамрагдсан.

- Стандарт, хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын газрын 21 аймгийн ахлах мэргэжилтэн, улсын байцаагч нарт 2024.03.21-ний өдөр Хорооноос ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт анхаарах асуудлын талаар мэдлэг, мэдээлэл зөвлөгөө өгөх цахим сургалтыг зохион байгуулсан.



"Орон нутгийн санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт зөвлөгөөн"-д Хорооноос 2024.03.15-ны өдөр "Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн хууль, эрх зүйн зохицуулалт, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага ба бусад зохицуулалт" сэдвээр мэдээлэл өгч хамтран ажилласан.

Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний холбоотой байгуулсан сургалтын гэрээний дагуу эрх олгох 6 удаагийн сургалтаар 200 оролцогчид салбарын зохицуулалттай холбоотой хууль журмын талаар холбогдох сургалтыг орсон.



Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 53 хуулийн этгээд, 453 иргэнээс нийт 105 санхүүгийн тайлан, 485 арилжааны мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлсэн 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн 4,000,000.00 төгрөгийн торгууль оногдуулсан.

Иргэд, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн салбарын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилан таниулах, иргэд олон нийтийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор танилцуулга бичлэг 1, сэрэмжлүүлэг бичлэг 5-ыг бүтээж, СЗХ-ны цахим хуудас болон олон нийтийн цахим хуудсаар дамжуулан түгээсэн.

Монгол үндэсний өв соёл, дахин давтагдашгүй, урлагийн бүтээл, бүтээгдэхүүн үйлчилгээг нь олон нийтэд сурталчлах зорилгоор үнэт металлын салбарын оролцогчдыг хамруулсан“ Mongolian jewellery & metal expo-2024” үзэсгэлэн худалдааг Хороо болон “Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн салбарын үндэсний мэргэжлийн нэгдсэн холбоо” ГҮТББ-тай хамтран 2024.04.12-ноос 2024.04.14-ний өдрүүдэд 3 өдрийн турш зохион байгуулж, Хорооноос ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдээр үйлчлүүлэх, тусгай зөвшөөрөлгүй иргэдийн гар дээрээс үнэт эдлэл худалдан авахгүй байх талаар иргэд, олон нийтэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 53 хуулийн этгээд, 453 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 4-өөр нэмэгдсэн бол иргэдийн тоо 8-аар буурсан үзүүлэлт юм.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 53 хуулийн этгээд нь 85 хувьцаа эзэмшигчийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 1.09 дахин, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.05 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ҮМҮЧЭТХЭАЭ 53 хуулийн этгээдийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 53.4 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 46.6 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 928.2 кг үнэт металлыг 148,201,987.2 мянган төгрөгөөр худалдан авч, 651.4 кг үнэт металлыг 144,590,817.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 1.9 дахин, худалдсан үнэт металлын хэмжээ 1.1 дахин тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2024 оны эхний хагас жилд 617.1 кг алтыг 146,988,661.6 мянган төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 1.4 дахин, үнийн дүн 2.3 дахин өсжээ. Харин 584.6 кг алтыг 143,704,981.1 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдсан алтны хэмжээ 1.1 дахин, үнийн дүн 1.9 дахин өссөн үзүүлэлт юм.

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 311.1 кг мөнгийг 1,213,325.6 мянган төгрөгөөр худалдан авч, 66.8 кг мөнгийг 885,838.7 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 7.7 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 1.8 дахин өссөн үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2024 оны эхний хагас жилийн тайлангийн нэгтгэлд 53 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 85 хувьцаа эзэмшигчдийн 10,063,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 74,868,745.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 53 хуулийн этгээд нь 42,420,078.5 мянган төгрөгийн нийт орлоготой, 34,713,462.3 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 7,706,616.3 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өссөн үзүүлэлт юм.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 99 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

2024 ОН